



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn

Цахим хаяг: www.audit.mn

2024. 07. 31 № 273

танай _____ -ны № _____ -т

Г Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд
заасан шаардлагад нийцсэн талаарх
дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох Говь-Алтай аймгийн Шарга сумын Монгол ардын намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

2024 оны Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь 2024 оны Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS6817-6:2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS6817-8:2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ШАРГА
СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ЭЭЛЖИТ СОНГУУЛЬД
ОРОЛЦОХ МОНГОЛ АРДЫН НАМД

0702 00896

Дүгнэлт

Говь-Алтай аймгийн Шарга сумын Монгол ардын намын Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Говь-Алтай аймгийн Шарга сумын Монгол ардын намын мөрийн хөтөлбөр (..... хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: Говь-Алтай аймгийн Шарга сумын Монгол ардын намд

Хувийг: Говь-Алтай аймгийн Шарга сумын Сонгуулийн хороонд

Хавсралт хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

Г.ГҮНЖИДМАА





ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРОО

ШАРГА СУМЫН ИТХ-ЫГ СОНГОХ 2024 ОНЫ 9 ДЭХ УДААГИЙН
ЭЭЛЖИТ СОНГУУЛЬД МАН-ААС ДЭВШҮҮЛСЭН

“СУМЫН СЭРГЭЛТ – ИРГЭДИЙН ОРОЛЦОО”
МӨРИЙН ХӨТӨЛБӨР
(2024-2028)

2024 он

Аймгийн МАН-ын хорооны
2024 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн
3/01 дугаар тогтоолын 2-дугаар хавсралт

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН “ШАРГА” СУМЫН МАН-ЫН ХОРООНЫ
ОРОН НУТГИЙН СОНГУУЛЬД ОРОЛЦОХ “СУМЫН СЭРГЭЛТ – ИРГЭДИЙН ОРОЛЦОО”
МӨРИЙН ХӨТӨЛБӨР
/2024-2028/

АГУУЛГА

НЭГ. БИДНИЙ АЛТАЙ

- ИРГЭДИЙН ОРОЛЦООТОЙ СУМЫН ТӨЛӨВЛӨЛТ
- ЭРЧИМ ХҮЧНИЙ ХАНГАМЖ

ХОЁР. ХҮРТЭЭМЖТЭЙ АЛТАЙ

- ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРТЭЭМЖ
- СУРГУУЛЬ, ЦЭЦЭРЛЭГИЙН ХҮРТЭЭМЖ
- НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ХҮРТЭЭМЖ
- АВТО ЗАМЫН ХҮРТЭЭМЖ

ГУРАВ. НОГООН АЛТАЙ

- ХУНСНИЙ ХАНГАМЖ, ЧАНАР АЮУЛГҮЙ БАЙДАЛ
- ТОХИЖИЛТ, НОГООН БАЙГУУЛАМЖ

ДӨРӨВ. ОРЛОГОТОЙ АЛТАЙ

- ШИНЭ ХОРШОО ХӨДӨӨГИЙН СЭРГЭЛТ
- ХУВИЙН ХЭВШЛИЙГ ДЭМЖИНЭ
- ӨМЧИЙН ЗӨВ МЕНЕЖМЕНТ
- СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ

Тав. АЮУЛГҮЙ АЛТАЙ

- ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧНЫ ОНОВЧТОЙ ТӨЛӨВЛӨЛТ
- ИРГЭДИЙН ОРОЛЦОО - НЭЭЛТТЭЙ ЗАСАГЛАЛ
- ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ

НЭГ. БИДНИЙ АЛТАЙ

1.1 ИРГЭДИЙН ОРОЛЦООТОЙ ТӨЛӨВЛӨЛТ

- 1.1.1 Сумын дэд бүтцийг сайжруулах зорилгоор салбар бүрт төсөв, болон төсөл хөтөлбөрийн хүрээнд иргэдийн оролцоотой төлөвлөгөө гарган хэрэгжүүлж ажиллана.
- 1.1.2 Сумын нийт малчин өрхийн 90 хүртэл хувьд үүрэн холбооны сүлжээнд хамаруулна.
- 1.1.3 Сумын ерөнхий төлөвлөгөөний дагуу сумын хөгжлийн бодлогыг хэрэгжүүлнэ.

1.2 ЭРЧИМ ХҮЧНИЙ ХАНГАМЖ

- 1.2.1 Сумын төвийн цахилгаан эрчим хүчний шугамын алдагдлыг бууруулах, шугам сүлжээг өрөтгөх арга хэмжээг хэрэгжүүлнэ.
- 1.2.2 Сумын төвийн нэгдсэн халаалтын системийн үйл ажиллагааг жигдрюүлж амины орон сууц, аж ахуйн нэгж, байгууллагуудыг холбоно.

ХОЁР. ХҮРТЭЭМЖТЭЙ АЛТАЙ

2.1. ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРТЭЭМЖ

- 2.1.1 Орон нутгийн эмч, эмнэлгийн ажилтны хүрэлцээ хангамж ур чадварыг сайжруулан, эмчилгээ оношилгооны шинэ дэвшилтэт арга барил эзэмшүүлж, нэвтрүүлэх зэрэг асуудлыг үе шаттай шийдвэрлэн.
- 2.1.2 Гадаад дотоодын байгууллагатай хамтын ажиллагааны гэрээ байгуулан эрүүл мэндийн болон биеийн тамирын мэргэжилтнүүдийг урт, богино хугацааны сургалтанд хамруулж, орон нутагт тогтвортой суурьшилтай ажиллуулна.
- 2.1.3 Эрүүл зан үйлийг хэвшүүлэх, халдварт бус өвчинөөс урьдчилан сэргийлэх зорилгоор эрүүл мэндийн сургалт сурталчилгааг тогтмолжуулна.
- 2.1.4 Эхийн эндэгдлийг гаргахгүй байх нөхцөлийг бүрдүүлж, 0-1 наасны хүүхдийн эндэгдлийг сумдын дунджаас бууруулна.
- 2.1.5 Эмч, эмнэлгийн ажиллагсын нийгмийн баталгааг хангаж, орон нутгийн нөөц бололцогоор нэн чухал шаардлагатай боловсон хүчийг бэлтгэж хангана.
- 2.1.6 Эрүүл мэндийн явуулын үзлэг, оношилгоог холбогдох дээд байгууллагатай хамтран, сум болон багт жил бүр зохион байгуулна.
- 2.1.7 Ахмадуудыг эмнэлгийн үзлэг оношилгоо, эмчилгээ сувилгаанд тогтмол хамруулна

2.2. СУРГУУЛЬ, ЦЭЦЭРЛЭГИЙН ХҮРТЭЭМЖ

- 2.2.1 Мэргэжлийн чадварлаг боловсон хүчинээр бүрэн хангагдсан, эрүүл мэнд, боловсрол, соёл, халамжийн үйлчилгээг чанаржуулж, хүртээмж, үр өгөөжийг нэмэгдүүлэн, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих замаар иргэн бүрийн амьдарлын чанарыг дээшлүүлнэ.
- 2.2.2 Боловсрол, соёлын салбарыг чадварлаг боловсон хүчинээр тасралтгүй хангагдах боломжийг бий болгож, удирдах ажилтны ур чадвар, арга барилыг дээшлүүлэх, өндөр мэргэшилтэй багш /Хими, Физик, Математик, Англи хэлний багшийг бодлогоор бэлтгэх /, соёлын ажилтнуудыг орон нутагт тогтвортой суурьшилтай ажиллах таатай орчныг бүрдүүлнэ.
- 2.2.3 Бүх нийтийн боловсролын түвшинг дээшлүүлэн, сургалтын материаллаг бааз, тоног төхөөрөмжөөр бүрэн хангаж, орчин үеийн дэвшилтэт сургалтын орчинг нэвтрүүлнэ.
- 2.2.4 Боловсрол, соёлын салбар дахь хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг бүхий л талаар дэмжиж, хувиараа нэмэлт болон гүнзгийрүүлэн судлах сургалтын орчинг бүрдүүлнэ.
- 2.2.5 Насан туршийн боловсролын хүртээмж, чанар, үр өгөөжийг дээшлүүлнэ.

- 2.2.6 Математик, англи хэл, компьютерийн сургалтын түвшинг нарийвчлан тогтоож, цаашид сайжруулах тусгай хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлнэ.

2.3 НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ХҮРТЭЭМЖ

- 2.3.1 Нийгмийн халамжийн үйлчилгээг зорилтот бүлэг, эмзэг бүлгийн иргэдэд хүртээмжтэй болгож, нийгмийн даатгалд хамрагдах хүрээг нэмэгдүүлж, тэтгэврийн суурь даатгалын тогтолцоонд сумын хүн амын хамралтыг нэмэгдүүлнэ.
- 2.3.2 Эдийн засгийн өсөлт, хөрөнгө оруулалтын арга хэмжээтэй уялдуулан ажлын байрыг түүштай нэмэгдүүлж, ажилгүйдлийн түвшинг багастган, өрхийн амьжиргааг дээшлүүлнэ.
- 2.3.3 Ажлын байр шинээр бий болгож буй аж ахуйн нэгж, байгууллагыг бүх түвшинд орон нутгийн бодлогоор дэмжинэ.
- 2.3.4 Байгаль орчныг хамгаалах, бүтээн байгуулалт, нийтийн эзэмшлийн зам талбай, ногоон байгууламжийн тохижилт үйлчилгээний ажилд амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой иргэдийг өргөнөөр татан оролцуулах замаар өрхийн орлогыг нэмэгдүүлнэ.
- 2.3.5 Хүүхэд залуучуудын хэрэгцээ шаардлагад сууриссан, сурч боловсрох, хөгжих, соёл хүмүүжил, хөдөлмөр эрхлэлтийг дэмжсэн "Нутгийн Залуус" дэд хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлнэ.
- 2.3.6 Ахмад настан, эмэгтэйчүүдийн хэрэгцээ чадамжинд сууриссан, хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, өрхийн орлогыг нэмэгдүүлэх хөтөлбөр боловсруулан байнгын орлоготой байх нөхцөлийг бүрдүүлнэ.
- 2.3.7 Ниймгийн эрүүл мэнд, боловсрол, соёлын салбарын хөгжилд шинэ өөрчлөлтийг бий болгоно.

2.4 АВТО ЗАМЫН ХҮРТЭЭМЖ

- 2.4.1 Аймгийн төвтэй засмал замаар холбогдох Нутгийн зам хөтөлбөрийг эхлүүлнэ.
- 2.4.2 Баг бүрт зам засварлаж түргэн тусlamжийн машин саадгүй явах нөхцлийг хангана.
- 2.4.3 Сумын төвд гол зам дагуу хатуу хүчилтэй замыг үргэлжлүүлэн барина.



ГУРАВ. НОГООН АЛТАЙ

3.1 ХҮНСНИЙ ХАНГАМЖ, ЧАНАР АЮУЛГҮЙ БАЙДАЛ

- 3.2.1 Байгальд ээлтэй амьдрах ухааны хичээл, сургалтыг бүх шатны боловсролын байгууллагатай хамтран хийж, өсвөрийн Байгаль хамгаалагчдыг удаан шингэдэг, задардаггүй хог хаягдал, сав баглаа боодлоос татгалзуулах ажлыг зохион байгуулна.
- 3.2.2 Мал сүргийг эрүүлжүүлэх арга хэмжээг тогтсон хугацаанд явуулан boom, шүлхий зэрэг олон улсын худалдааны хорио цээр, өвчинөөс эрүүл бүсийн статусаа хадгалж халдварт өвчний гаралтыг бууруулна.
- 3.2.3 Төмс, хүнсний ногоо хадгалах стандартын шаардлага хантасан зоорьтой болгох асуудлыг судалж шийдвэрлэнэ.

3.2 ТОХИЖИЛТ, НОГООН БАЙГУУЛАМЖ

- 3.2.1 Сумын төвд иргэдийн оролцоотой хамтарч Жишиг гудамж төсөл хэрэгжүүлнэ.
- 3.2.2 Байгальд ээлтэй амьдрах ухааны хичээл, сургалтыг бүх шатны боловсролын байгууллагатай хамтран хийж, өсвөрийн Байгаль хамгаалагчдыг удаан шингэдэг, задардаггүй хог хаягдал, сав баглаа боодлоос татгалзуулах ажлыг зохион байгуулна.
- 3.2.3 "Хоггүй цэвэрхэн сум" хөдөлгөөнийг бүх шатанд өрнүүлж, хамтдаа эрүүл цэвэр амьдрах орчныг бүрдүүлнэ.

ДӨРӨВ. ОРЛОГОТОЙ АЛТАЙ

4.1 ШИНЭ ХОРШОО ХӨДӨӨГИЙН СЭРГЭЛТ

- 4.1.1 Эдийн засгийн тэнцвэрт байдлыг хангаж, хөгжилд чиглэсэн төсвийн бодлого "Шинэ хоршоо -Хөдөөгийн сэргэлт" хөтөлбөрт тулгуурлаж хэрэгжүүлэн үр ашгийг нь нэмэгдүүлж, ажлын байр бий болгон ард иргэдийн өрхийн орлогыг нэмэгдүүлнэ.
- 4.1.2 Төсөл хөтөлбөрийн нэгдсэн бодлого боловсруулж, өрх бүрийг жигд хамрагдах боломжийг бүрдүүлж, "Шинэ Хоршоо" хөтөлбөрийг хэрэгжүүлж хувиараа бизнес эрхлэгчид болон малчдын орлогыг нэмэгдүүлнэ.
- 4.1.3 Орон нутгийн эдийн засгийг тэлэх бодлогыг баримталж, байгууллага аж ахуйн нэгжийн санхүүгийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх, айл өрх, иргэд, худалдаа эрхлэгчдийн орлогыг өсгөхөд шаардагдах орон нутгийн шийдвэрүүдийг богино хугацаанд гаргаж ажиллана.
- 4.1.4 Орон нутгийн нөөц бололцоонд тулгуурлан малын таваарлаг байлдыг нэмэгдүүлэх бодлогыг хэрэгжүүлж ажиллана.
- 4.1.5 Сумын өвс тэжээлийн нөөцийг бүрдүүлэх, нөөцийг нэмэгдүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.
- 4.1.6 Жил бүр 3 хүртэл инженерийн хийцтэй болон энгийн уурхайн худаг шинээр гаргаж худаг уст цэг болон хөвийг сэргээн засварлах болон шинээр гаргаж бэлчээр усжуулах ажлыг ээлж дараатайгаар зохион байгуулна.
- 4.1.7 Бэлчээрийг улирлын хуваарийн дагуу ашиглах, өнжөөж сэргээх, хашиж хамгаалах зэрэг арга хэмжээг тууштай хэрэгжүүлж, хортон мэрэгчидтэй тэмцэх ашигтай аргыг нэвтрүүлж, үр дүнг дээшлүүлнэ.
- 4.1.8 Хөдөө аж ахуйн үйлдвэрлэгчдийн хоршоодын үйл ажиллагааг эрчимжүүлэн дэмжиж, биржийн арилжаанд оролцох эрхтэй иргэд, аж ахуйн нэгжүүдийг бий болгоно.
- 4.1.9 Max экспортлох байрлалын давуу боломжкоо ашиглан сум дундын стандартын шаардлага хангасан нядалгааны цехийг бий болгох асуудлыг бодлогоор дэмжинэ.
- 4.1.10 Ямааны хээлтүүлэгчийг чанаржуулах замаар ноолуурын чанар гарцыг сайжруулна.
- 4.1.11 Малын гаралтай түүхий эд боловсруулах баға оврын цех байгуулна.
- 4.1.12 Сумын хэмжээнд тогтоогдсон усалгаатай тариалан эрхлэх боломжтой газруудыг эргэлтэнд оруулах зорилт тавьж, төмс хүнсний ногооны хэрэгцээг 50 хүртэл хувь хангах бодлого хэрэгжүүлнэ.
- 4.1.13 Хүлэмжийн аж ахуй хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлж, өвлийн дулаалгатай хүлэмжийн тариалалтыг нэмэгдүүлнэ.
- 4.1.14 Орон нутагт байгаа байгалийн баялагийг судлах, нээх, илрүүлэх, хайгуул судалгааны ажлыг мэргэжлийн байгууллагаар зохих зөвшөөрлийн үндсэн дээр хуулийн хугацаанд багтаан хийлгэх шаардлага тавьж орон нутаг, төдийгүй улсын хэмжээний стратегийн ач холбогдол бүхий томоохон ордыг нээх, ашиглах асуудлыг дэмжиж түүнд ажиллах боловсон хүчин ажиллах хүчийг орон нутгаас хангах бодлого барин ажиллана.
- 4.1.15 Ажилгүй, амьжирааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой иргэдэд мэргэжил олгох сургалт зохион байгуулж, бүлэг, нөхөрлөл, хоршоололд хамруулан ажлын байртай болоход нь дэмжлэг үзүүлнэ.

4.2 ХУВИЙН ХЭВШЛИЙГ ДЭМЖИНЭ

- 4.2.1 Сум орон нутагт бизнес эрхлэгчдийн үйл ажиллагаа эрхлэх таатай орчинг бүрдүүлж ажиллана.
- 4.2.2 Эдийн засгийн чадавхийг бэхжүүлэх зорилгоор бичил уул уурхай, алт олборлогчдын бүлэг, нөхөрлөлийн эрх ашгийг хамгаалж, үр өгөөжийг нэмэгдүүлэх чиглэлийн арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

- 4.2.3 Сум бүрт брэнд бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхлэхийг дэмжин, стандарт, эрүүл, ахуйн шаардлагад нийцсэн бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэх боломжийг бүрдүүлж, борлуулалтын сүлжээ бий болгоно.
- 4.2.4 Жижиг дунд болон өрхийн үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ эрхлэгчдийг төсөл хөтөлбөрүүдэд хамруулан, ажлын үр өгөөж, хүртээмжийг дээшлүүлнэ.
- 4.2.5 Гарааны бизнес эрхлэгчдэд аж ахуй эрхлэх сургалтуудыг зохион байгуулж, тэднийг шаардлагатай мэдээ мэдээллээр хангах, техник технологийн сонголт хийхэд нь туслах, төсөл боловсруулах явцад нь зөвлөгөө өгөх ажиллагааг зохион байгуулна.
- 4.2.6 Хувийн хөрөнгө оруулалтыг эдийн засгийн бодит салбарт оруулах нөхцөл боломжийг дэмжиж, эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлнэ.

4.3 ӨМЧИЙН ЗӨВ МЕНЕЖМЕНТ

- 4.3.1 Орон нутагт хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг ханган олон улсын болон үндэсний хөрөнгө оруулалтын сүлжээг татах, хэрэгжүүлэхэд таатай нөхцөлийг бий болгоно.
- 4.3.2 Олон улсын болон орон нутгийн төсөл хөтөлбөрүүдийн уялдаа холбоог сайжруулна.
- 4.3.3 Орон нутгийн өмчийн хадгалалт, ашиглалтанд тавих олон нийтийн хяналтыг нэмэгдүүлж, бүргэлийг сайжруулна.

4.4 СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ

- 4.4.1 Нийтийн биеийн тамирыг бүх нийтийн хүртээл болгон хүн амыг хөдөлгөөний хомсдооос урьдчилан сэргийлэх, ажлыг эрчимжүүлж, чийрэгжүүлэх танхимыг сумын төв, байгууллагуудад зохистой хэлбэрээр бий болгон хөгжүүлж, 2028 он гэхэд хүн амын дундаж наслалтыг улсын дундаж түвшинд хүргэх нөхцөлийг бүрдүүлнэ.
- 4.4.2 "Алтайн аваргууд" хөтөлбөрийг хэрэгжүүлж сумд дэд хөтөлбөр боловсруулан өсвөр үеийн тамирчдыг спортын 8 төрлөөр бэлтгэж, өсвөр үеийн тамирчдыг дэмжиж ажиллана.
- 4.4.3 Хүүхэд залуучуудыг өвлийн спортоор хичээллэх нөхцөлийг бүрдүүлнэ.
- 4.4.4 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг биеийн тамир, спортоор хичээллэх, уралдаан тэмцээнд оролцох нөхцөлөөр хангана.
- 4.4.5 Хүүхэд залуучуудыг биеийн тамир, спортоор хичээллэх боломж нөхцөлийг бүрдүүлж, сумын спорт заалыг шинэчлэх, засварлах ажлыг үе шаттай зохион байгуулна.
- 4.4.6 Урлагийн гоц авьяастан, урчууд, уран бүтээлчдийг тодруулан авьяасыг нь хөгжүүлэх хөтөлбөр, төслүүдийг хэрэгжүүлнэ.
- 4.4.7 Сумын соёлын биет болон биет бус өвийг хадгалах, өвлүүлэх олны хүртээл болгох чиглэлээр хийгдсэн ажлуудыг бататгаж, дэлхийн соёлын өвд бүртгүүлэх, томоохон хэмжээний зан заншил соёл, өв тээгчдийг илрүүлэн алдаршуулах, баталгаажуулах ажлыг зохион байгуулна.

ТАВ. АЮУЛГҮЙ АЛТАЙ

5.1 ХҮРЭЭЛЭН БҮЙ ОРЧНЫ ИНОВЧТОЙ ТӨЛӨВЛӨЛТ

- 5.1.1 Хүний үйл ажиллагаанаас үүдэлтэй байгаль орчны бохирдол, доройтлыг хязгаарлан зогсоож, хүн амын эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлж, орон нутгийн онцлогт тохирсон аялал жуулчлалыг хөгжүүлнэ.
- 5.1.2 Сумын төвийн ногоон байгууламжийн усалгаа, арчилгааг бүрэн шийдвэрлэж, "НОГООН ОРЧИН" хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлнэ.

- 5.1.3 Байгууллага, аж ахуйн нэгж бүрийг хуулийн дагуу ойжуулах, цэцэрлэгжүүлэх ажилд дайчлан оролцуулах замаар "НОГООН БАЙГУУЛЛАГА", "НОГООН ХАШАА" бий болгоно.
- 5.1.4 Мод тарьсан иргэдэд дэмжлэг үзүүлэх журам гарган хэрэгжүүлж, мод үржүүлэн орлого олох боломжийг бүрдүүлнэ.
- 5.1.5 Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх санг хуулийн дагуу бүрдүүлж, байгалийн нөөцийг нэмэгдүүлэх ажлыг санхүүжүүлнэ.
- 5.1.6 Голын ай сав, цөлжилт, элсний нүүдэл бүхий газруудыг ойжуулах иргэд, аж ахуйн нэгжийн санал санаачилгыг дэмжиж ажиллана.
- 5.1.7 Байгалийн үзэсгэлэнт газруудыг түшиглэн аймгийн хэмжээний аялал жуулчлалын маршрут гаргаж тэдгээрийн онцлогыг харуулсан богино хэмжээний баримтат кино, шторкуудыг мэргэжлийн өндөр түвшинд хийлгэн сурталчилж, гадаад, дотоодын аялал жуулчлалыг шинэ шатанд гарган орон нутгийн жуулчдын тоог нэмэгдүүлнэ.
- 5.1.8 Аялал жуулчлал эрхлэх аж ахуйн нэгж, иргэдийн цогцолбор, бааз байгуулах төслүүдийг хэрэгжүүлэхэд хамтарч, онцгойлон дэмжиж ажиллана.
- 5.1.9 Аялал зугаалга, уул овооны тахилга зохион байгуулсан газар нутгийн хог хаягдлыг цэвэрлэн ариутгаж тухайн засаг захиргааны нэгжид хүлээлгэн өгдөг журмыг хэвшүүлнэ.
- 5.1.10 Сумын бахархалт гайхамшигт газар, ан амьтан, уул усны дүрстэй бэлэг дурсгалын зүйл үйлдвэрлэж борлуулах эрхийг сонгон шалгаруулалтаар олгох ажлыг эхлүүлнэ.
- 5.1.11 Хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүдийн тайланг гаргуулан, дүгнэлт хийж, байгаль орчинд ээлтэй үйл ажиллагааг дэмжиж ажиллана.
- 5.1.12 Нөхөн сэргээлтийг орон нутгийн иргэдийн оролцоотойгоор зөв менежмент хийж зохион байгуулах бодлогыг барина.
- 5.1.13 Улсын тусгай хамгаалалттай газар нутгийг өргөжүүлэх, аймаг, сумын тусгай хамгаалалттай газар нутгийг шинэчлэн баталгаажуулах, ховор амьтан ургамал, түүх соёлын газрын хамгаалалтыг сайжруулах арга хэмжээ авна.
- 5.1.14 Орон нутаг дахь уул уурхайн үйлдвэр, аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд явуулах хяналтыг сайжруулж, хамтын ажиллагааг өргөжүүлнэ.
- 5.1.15 Байгаль орчны хуулийн дагуу иргэн бүр мэдээлэгч-хамгаалагч байх тогтолцоог бүрдүүлэн, урамшууллын систем тогтоож хэрэгжүүлнэ.
- 5.1.16 Ан амьтдын тооллогыг орчин үеийн багаж, тоног төхөөрөмж, арга хэрэгсэл ашиглан хийж, нөөцийн судалгааг шинэчлэн, байгаль хамгаалагчдын ажиллах нөхцөл боломжийг дээшлүүлнэ.
- 5.1.17 Усны нэгдсэн менежментийн төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлж, булаг, шанд, уст цэгийн тоог нэмэгдүүлэх, хамгаалах ажлыг тогтмол зохион байгуулна.
- 5.1.18 Хайгуул хийгдэж, нөөц нь тогтоогдоогүй орд, илэрцэд ашиглалтын тусгай зөвшөөрөл олгохыг хориглоно.
- 5.1.19 Заган ой, модлог ургамлын хамгаалалтын хяналтыг сайжруулан хамгаална.
- 5.1.20 Булаг шандны эхийг хамгаалан, моджуулж, ургамалжуулах ажлыг малчид, хоршоо, нөхөрлөлтэй хамтран хийж, усны ундаргыг нэмэгдүүлнэ.
- 5.1.21 Усны харуулын тоог нэмэгдүүлж, үүлэнд зориуд нөлөөлөх, хур тундасны хэмжээг нэмэгдүүлэх ажлыг мэргэжлийн байгууллагатай хамтран явуулна.

5.2 ИРГЭДИЙН ОРОЛЦОО - НЭЭЛТТЭЙ ЗАСАГЛАЛ

- 5.2.1 Иргэдийнхээ итгэл дэмжлэгийг хүлээсэн төрийн хариуцлагатай тогтолцоог төлөвшүүлнэ.
- 5.2.2 Төрийн албаны ажлын байранд тавигдах шаардлага бүрэн хангаж, нээлттэй шалгаруулалтанд шалгарсан хүнийг төрийн албанд томилдог зарчмыг бүрэн хэрэгжүүлнэ.
- 5.2.3 Бүх шатны Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, багийн Иргэдийн нийтийн хуралд зөвшилцлийн зарчмыг тууштай баримталж, цөөнхийг хүндэтгэж, оновчтой санал, санаачилгыг нь дэмжиж ажиллана.
- 5.2.4 Төрийн албаны "Боловсон хүчний хөтөлбөр"-ийг шинэчлэн боловсруулж хэрэгжүүлнэ.
- 5.2.5 Тулгамdsan, нэн шаардлагатай зорилтуудыг олж тодорхойлох, тэдгээрийг шийдвэрт тусгаж хэрэгжүүлэхийн тулд бүх шатны Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчдийн үйл ажиллагааг тогтмолжуулж, шаардлагатай асуудлаар нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулдаг болно.
- 5.2.6 Төрийн ажил үйлчилгээг иргэдэд нээлттэй хөнгөн шуурхай, чирэгдэл, хүндэрэлгүй байлгах бүх нөхцөл шаардлагыг сумын түвшинд жигд хэрэгжүүлж ажиллана.
- 5.2.7 Хөдөөгийн багуудын ажлын нөхцөлийг сайжруулж, багийн дарга, эмч нарыг багт тогтмол ажиллуулах боломжийг бүрдүүлнэ.
- 5.2.8 Иргэд хөдөлмөрчдийн хурал, багийн иргэд нийтийн хурлуудыг сар улирал бүр зохион байгуулж иргэдийн санал хүсэлтийг хүлээн авч хэвшинэ.
- 5.2.9 Төрийн байгууллагуудын хүнд сурталгүй, зарчимч, шуурхай, ил тод, нээлттэй нам эвсэл үзэл бодлоор нь ялгаварлан гадуурхаяас ангид ажиллана.
- 5.2.10 Нэг цэгийн үйлчилгээ, шилэн данс, төрийн албаны бусад цахим үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлж, хүрээг өргөтгөнө.
- 5.2.11 Төрийн нууцад хамаархаас бусад мэдээлэлтэй иргэд тогтмол танилцаж байх боломжоор хангана.
- 5.2.12 Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний байгууллагуудын хүнд суртлыг арилган, иргэдэд чирэгдэлгүй хөнгөн шуурхай үйлчилгээ үзүүлэх зорилготой иргэдэд үйлчлэх нэгдсэн төвийг байгуулж, ажиллуулна.

5.3 ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ

- 5.3.1 Малын хулгайтай тууштай тэмцэж, малын хулгайгүй сум болохыг зорино.
- 5.3.2 Хууль сахиулах байгууллагуудын албан хаагчдын ёс зүйг сахиулж, хүний эрх, эрх чөлөөг хангана.
- 5.3.3 Төв суурин газрын хяналтын камерын тоо, хүчин чадлыг нэмэгдүүлж гэмт хэргээс урьдчилан сэргийлэх орчныг бүрдүүлнэ.